


ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Сарын тойм: 2016 оны 3 дугаар сар




МХБ-ийн индексүүд

Топ-20 индекс, 10,995.4 -18.28% (өмнөх оны мөн үетэй харьцуулсан өөрчлөлт)



MSE ALL индекс, 797.57 -18.17% (индексийн анхны өдөртэй харьцуулсан өөрчлөлт)



МХБ Топ-20 багцад багтах хувьцааны ханшийн өөрчлөлт

Компанийн нэр	Санал*	6/IV	Өөрчлөлт
Таван толгой ХК (TTL)	Авах	999.98	-36.83%
Багануур ХК (BAN)	Авах	1467	-33.32%
Шарын гол ХК (SHG)	Авах	2050	-31.46%
Шивээ овоо ХК (SHV)	Авах	2250	-25.00%
Гермес центр ХК (HRM)	Авах	125	-10.07%
Женко тур бюро ХК (JTB)	Авах	80	-9.09%
Улсын их дэлгүүр ХК (UID)	Хүлээх	551.65	-7.90%
Дархан нэхий ХК (NEH)	Авах	18000	-7.69%
Баянгол зочид буудал ХК (BNG)	Авах	45000	-6.25%
Хөх ган ХК (HGN)	Хүлээх	60	-6.25%
Э-Транс ложистикс ХК (ETR)	Хүлээх	111.9	-2.70%
Хай би ойл ХК (HBO)	Хүлээх	380	-2.56%
Махимпекс ХК (MMX)	Авах	2902	-0.96%
Говь ХК (GOV)	Авах	8155	+0.31%
АПУ ХК (APU)	Хүлээх	3699	+0.52%
Мерекс ХК (MRX)	Авах	70.42	+0.60%
Ариг гал ХК (EER)	Хүлээх	2200	+2.33%
Талх чихэр ХК (TCK)	Авах	17000	+3.03%
Би ди сек ХК (BDS)	Хүлээх	1684	+5.18%
УБ-БҮК ХК (BUK)	Хүлээх	35000	+16.67%

* Богино хугацаанд

Эх сурвалж: МХБ

Олон улсын индексүүд

Индекс	Өмнөх оны мөн үетэй харьцуулсан өөрчлөлт	2016.01.01-гэй харьцуулсан
DJIA (US)	+1.06%	+1.02%
Nikkei 225 (JP)	-17.52%	-17.43%
Hang Seng (HK)	-17.23%	-7.79%
DAX 30 (DE)	-20.27%	-11.19%
SMI (CH)	-12.79%	-12.80%
MSE 20	-18.28%	-14.75%

Эх сурвалж: Блумберг

Валютын ханш

	2016.03.06	2016.04.06	Өөрчлөлт
USD - ТӨГ	2,042.34	2042.75	0.02%
EUR - ТӨГ	2,235.85	2320.56	3.79%
JPY - ТӨГ	17.93	18.51	3.23%
CHF - ТӨГ	2,057.26	2130.75	3.57%

Эх сурвалж: Монголбанк


Үнэт цаасны зах зээлийн мэдээ

Хувьцааны арилжаа

МХБ-ээр 2016 оны 3-р сард нийт 0.52 тэрбум төгрөгийн дүнтэй арилжаа хийгдэж, 69 компанийн 386,071 ширхэг хувьцаа арилжигджээ. Энэ нь өмнөх оны мөн үед хийгдсэн арилжааны дүнтэй харьцуулахад 2.56 дахин бага үзүүлэлт байсан бол өмнөх 2-р сарын 1.34 тэрбум төгрөгийн арилжааны дүнтэй харьцуулахад мөн 2.1 дахин бага дүнтэй байжээ.

ЗГҮЦ-ны арилжаа

ЗГҮЦ нь 2014 оны 11-р сараас эхлэн арилжигдсан ба 2016 он гарсаар нийт 38.4 тэрбум төгрөгийн хэмжээтэй арилжаа хийгдсэн байна. Өнөөг хүртэл хийгдсэн ЗГҮЦ-ны арилжааны ихэнх нь 12 долоо хоногтой ЗГҮЦ-ны арилжаа байсан ба



дундаж хүү нь 14.72 хувьтай байжээ. Сүүлийн үед ЗГҮЦ-ны эрэлт нийлүүлэлтээс бага байна. 2016 оны 4-р сарын 11-ний өдөр 39 долоо хоногтой 14,394 хувийн хүүтэй мөн 2 жилийн хугацаатай, 15.5 хувийн хүүтэй ЗГҮЦ арилжигдана.

Монголын үнэт цаасны бирж “Бүртгэлийн журам”-аа танилцуулав

“Монголын үнэт цаасны бирж” ХХК нь анх 2015 оны 7-р сарын 3-ны өдөр “Дилерүүдийн арилжааны төв” ХХК нэртэйгээр байгуулагдаж, үнэт цаасны арилжаа эрхлэх, үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг СЗХ-оос авсан. Ийнхүү Монголын үнэт цаасны бирж /МҮЦБ/ байгуулагдсан нь зах зээл дээр дангаараа 25 жил үйл ажиллагаа явуулсан МХБ ТӨХК-д өрсөлдөөн үүсгэж байгаа юм. Тус бирж нь “Насдак” групптэй хамтран ажиллаж байгаа ба 2017 оноос “Насдак” арилжааны системийг хэрэглэж эхлэх юм байна. 2016 он гарсаар МҮЦБ нь үйл ажиллагааны гол журмуудаа СЗХ-оор батлуулсан байна. Хөрөнгө оруулагчдын хэрэгцээнд нийцсэн чанартай бүтээгдэхүүнийг гаргахад чиглэсэн “Бүртгэлийн журам” боловруулсан гэж андеррайтерийн компаниудад танилцууллаа. Тус биржид бүртгүүлэхээр компаниуд хүсэлтээ гаргаж эхэлжээ.

Монголын Засгийн газар 500 сая ам.долларын бондыг олон улсын зах зээлд арилжлаа


Монгол Улсын Засгийн газар олон улсын зах зээлд 5 жилийн хугацаатай 10.875 хувийн хүүтэй 500 сая ам.долларын өрийн бичгийг арилжсан байна. Тус бондын санхүүжилтийг голчлон дэд бүтцийн төслүүдийг болон өмнө нь авсан зээлийн хүүг нөхөхөд зориулах ажээ. Энэхүү бондын хүү 2012 оны Чингис бондын хүү болох 4.125 хувиас 2.6 дахин өндөр байгааг 2015 оны эцсийн байдлаар Монгол Улсын төлбөрийн тэнцэл буурсан, гадаад өрийн нийт хэмжээ ДНБ-ний 180 хувьд хүрсэн, улсын өр 80 хувьд хүрсэн, гадаад валютын нөөц 1.3 тэрбум ам.долларт хүрч буурсантай холбож байна. Уг бондын андеррайтераар Credit Suisse, Deutsche Bank, ING, JP Morgan, ТБД Капитал болон Голомт Банкууд ажилласан байна.

2016 онд Монгол Улсын инфляцийн төлөв байдал

2016 оны 3-р сарын Монголбанкны “Инфляцийн төлөв байдлын тайлан”-д мэдээлснээр 2016 оны эхний 3-н улиралд хүнсний бүтээгдэхүүний үнийн дарамт багасах хүлээлттэй холбоотойгоор ерөнхий инфляци үргэлжлэн буурах төлөвтэй байгаа бол 2016 оны II хагаст Оюу Толгойн хоёр дахь шатны хөрөнгө оруулалттай холбоотойгоор эдийн засаг идэвхжин инфляци өсөх хүлээлттэй байна. Харин АХБ инфляцийн түвшинг 2016 онд 3 хувьд, 2017 онд 7 хувьд байхаар таамагласан байна.

Монгол Улсын банкны хадгаламжийн хүү болон хадгаламжийн үлдэгдэл


2013 оны эхнээс 2016 оны 2-р сарын хооронд Монгол Улсын нийт хадгаламжийн хэмжээ бага багаар өсч байгаа ба 2016 оны 2-р сарын байдлаар нийт хадгаламжийн хэмжээ 7.4 их наяд төгрөгт хүрсэн байна. Энэ нь 2013 оны эхэн үетэй харьцуулахад 50.7 хувь өссөн дүн юм. Энэхүү 7.4 их наяд төгрөгийн хадгаламжийн 72.2 хувь буюу 5.4 их наяд төгрөг нь төгрөгийн хадгаламж бол 27.8 хувь нь валютын хадгаламж байна. Мөн төгрөгийн хадгаламжийн 81.8 хувийг иргэдийн хадгаламж бүрдүүлсэн байна. Иргэдийн хадгаламж 2013 оны эхэн үетэй харьцуулахад 38.4 хувиар нэмэгдсэн авч нийт хадгаламжид эзлэх хувь буурсан байна. Гадаад валютын хадгаламжийн хэмжээ 2013 оны эхэн үетэй харьцуулахад үнийн дүнгээр өссөн ба нийт хадгаламжид эзлэх хувь нь мөн өссөн дүнтэй байна. Энэ нь Монгол төгрөгийн ханш буурах хүлээлттэй холбоотойгоор иргэд валютын хадгаламжийг илүүд үзэж байгааг харуулж байна.




Төгрөгийн хадгаламжийн хүү 2016 оны 2-р сард 13.5 байсан бол гадаад валютын хадгаламжийн хүүгийн хэмжээ 6.7 хувьд хүрч, 2013 оны эхэн үетэй харьцуулахад 1.8 болон 0.5 нэгжээр тус тус өссөн байна. Түүнчлэн сүүлийн 3 жилийн хугацаанд бодлогын хүүнд багагүй өөрчлөлт орсон. Хамгийн сүүлд 2016 оны 1-р сарын 14-ний байдлаар бодлогын хүүг 1 нэгжээр бууруулж, 12 хувь болгосон байна.

Валютын ханш

2013 оноос хойш евро болон долларын ханш өссөөр байгаа ба 2016 оны 3-р сарын байдлаар доллар 46.9 хувиар, евро 22.9 хувиар тус тус өссөн байна.



Харин ОХУ-ын гадаад бодлоготой холбоотойгоор рублийн ханш гадаад валютын эсрэг унаж эхэлсэн нь төгрөгийн эсрэг уналтыг мөн үзүүлсэн. 2013 оны эхэн үетэй харьцуулахад рублийн ханш 36.6 хувь буурчээ.



Монгол Улсын валютын нөөц багассантай холбоотой ам.долларын ханш өссөн дүр зураг харагдаж байна. 1.5 тэрбум ам.долларын Чингис бонд арилжаалагдсны дараа Монгол Улсын валютын нөөцийн хэмжээ 2012 оны 12-р сард 4.1 тэрбум ам.долларт хүрч, тэр үед ам.долларын ханш 1,396.11 төгрөг байсан нь түүнээс хойш тасралтгүй өссөөр валютын нөөц өнөөдөр 1.2 тэрбум ам.долларт хүрсэн ба ам.долларын ханш 2,042 төгрөг болсон байна. Валютын нөөцийн хэмжээ нь Монгол Улсын экспортын орлоготой шууд хамааралтай бөгөөд Стандарт инвестмент ҮЦК-аас гаргасан “2015 оны тойм мэдээ”-нд дурдсанчлан манай улсын экспортын орлого 2016 онд үргэлжлэн буурах төлөвтэй байна. Харин Оюу Толгойн хөрөнгө оруулалт төлөвлөсөн ёсоор хийгдвэл нийт гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ 1 тэрбум ам.доллар хүрэх хүлээлттэй байна. Ийнхүү валютын нөөцийн хэмжээ ихэсч, валютын ханшийн өсөлтийг сааруулах хэдий ч валютын ханшийн өсөлт үргэлжлэх магадлалтай байна.



Эх сурвалж: Монгол банк

2015 оны IV улирлын санхүүгийн тайлангийн мэдээлэл

МХБ-д бүртгэлтэй хувьцаат компаниуд хагас жил болон жилийн эцэст санхүүгийн тайланг МХБ-ээр олон нийтэд тайлагнах үүрэгтэй байдаг. Одоогийн байдлаар IV улирлын байдлаар 67 компанийн санхүүгийн тайлан олон нийтэд нээлттэй болсон байгаа ба тэдгээрийн 10 нь төрийн өмчит хувьцаат компани байна. Өмнөх сарын тойм мэдээнд 33 хувьцаат компанийн санхүүгийн мэдээллийг оруулсан бол энэ удаад 14 компанийн санхүүгийн зарим тоон мэдээллийг орууллаа. Мэдээллийг үнэ эзэмшигчдийн өмч (P/B)-ийн үзүүлэлтээр нь дарааллуулан орууллаа. Уг үзүүлэлт нь хувьцааны ханш нь тухайн компанийн нэгж хувьцаанд оногдох эзэмшигчдийн өмч буюу дансны үнээс илүү, эсвэл дутуу үнэлэгдсэн эсхийг тодорхойлдог. Хөрөнгө оруулагчид хувьцааг авах зарах шийдвэрийг гаргахдаа энэхүү үзүүлэлтийг онцгойлон анхаардаг.

Сим-бол	Хувьцаат компанийн нэр	Нийт хөрөнгө, мян.төг	Өр төлбөрийн нийт дүн, мян.төг	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал), мян.төг	Хувьцааны ханш, төг 2016.04.06	Дансны үнэ, төг	P/B	P/E
ALA	Алтайн нэгдэл	955,934.2	174,148.7	9,180	350	7,567.52	0.05	3.94
NXE	Нэхээсгүй эдлэл	9,981,263	8,381,668	23,990	1,145	19,409	0.06	3.93
INT	Ингэт толгой	1,822,251.4	977,519.4	18,946.6	138	1,352.91	0.10	4.55
ETR	Е-транс ложистик	6,206,525.2	317,919.80	61,643.9	111.9	109.16	1.03	83.87
BUK	УБ БУК	38,934,217.6	4,241,460.5	(1,500,054.8)	35,000	30,748.49	1.14	(26.33)
ТАН	Тахь ко	14,067,170.1	60,413.8	1,127,034.1	19,000	11,767.69	1.61	20.06
TTL	Тавантолгой	56,971,117.98	28,370,405.3	572,070.4	965.2	537.66	1.80	88.86
ZOO	Зоос гоёл	1,949,545	45,371.7	253,006.5	265,000	146,010.5	1.81	13.66
BHG	Бөхөг	3,355,719	1,768,813.9	(543.8)	7,000	3,470.22	2.02	(5,886)
MIK	МИК холдинг	2,167,353,263	2,053,918,935	30,374,966	11,250	5,477.45	2.05	7.67
MSH	Монгол шилтгээн	5,538,869.8	2,607,093.4	-117,367.1	700	293.18	2.39	(59.6)
SIL	Силикат	2,661,318	1,577,931	18,194	225	21.69	10.38	573.01
TSA	Цагаантолгой	69,514.9	9,041	-6,906	6,650	545.73	12.19	(106.7)
BAN	Багануур	123,436,990.1	121,906,432.9	(13,011,160.6)	1,510	58.57	25.78	(2.43)

P/B- Үнэ эзэмшигчдийн өмчийн харьцаа
P/E- Үнэ ашгийн харьцаа

Эх сурвалж: МХБ

Ногдол ашиг тараалтын мэдээлэл

2015 оны жилийн эцсийн байдлаар ашигтай ажилласан дараах хувьцаат компаниудын Төлөөлөн удирдах зөвлөл ногдол ашиг тараах шийдвэрийг гаргасан байна.

Симбол	Компанийн нэр	2015 оны нэгж хувьцаанд ногдох ногдол ашиг, төгрөг
APU	АПУ ХК	70
BTG	Баянтээг ХК	100
SUL	Газар сүлжмэл ХК	10,201.91
GHC	Ган хийц ХК	100
HRM	Гермес төв ХК	4.39
GOV	Говь ХК	140
GTL	Гутал ХК	749
ZOO	Зоос гоёл ХК	17,000
MIE	Материал импекс ХК	30
MMX	Мах импекс ХК	100
MIK	Мик холдинг ХК	241.2
TCK	Талх чихэр ХК	130
ТАН	Тахь-Ко ХК	108

Эх сурвалж: МХБ

Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй • Монголын хөрөнгийн биржийн гишүүн • Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн

4-р сард хуралдах ХЭХ-ийн товууд

Хуралдах он, сар, өдөр	Компанийн нэр	Хурал эхлэх цаг	Хуралдах газар	Бүртгэлийн өдөр	Хэлэлцэх асуудлууд	Холбогдох утас
2016.04.09	Барилга корпораци	10:00	УБ, Барилгачдын талбай-13, Застгийн Газрын 12-р байрны Зүүн Хойд Өргөгдөлийн 4А-1	2016-03-07	1. ТУЗ-ийн тайлан, 2. Компанийн 2015 оны үйл ажиллагааны үр дүнгийн тайлан, 2016 оны үйл ажиллагааны чиглэл, 3. 2015 оны санхүүгийн тайлан, 4. Хөндлөнгийн Аудитын дүгнэлт, 5. Бусад асуудал	70003247, 70004613
2016.04.10	Номин Хишиг	10:00	Баянхонгор аймаг компанийн байранд	2016-03-20	1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан аудиторын дүгнэлт 2. Аудитын байгууллагыг сонгох 3. Хянан шалгах зөвлөлийн тайлан 4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох 5. ХЗ-ийн гишүүд сонгох	96446363, 99265644, 86835959
2016.04.11	Багануур	10:00	УБ, Баянзүрх дүүрэг, 18-р хороо, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж, “Багануур” ХК-ийн төлөөлөгчийн газар	2016-03-11	1. Нэмж гаргах хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэх эсэх, 2. Тэргүүн ээлжинд худалдан авах хувьцааны үнэд хуулинд заасан хэмжээнд хөнгөлөлт эдлүүлэх эсэх,	99815690, 99044373, 88082547
2016.04.11	Хүрд	16:00	УБ, ЧД 6-р хороо, Сүхбаатарын гудамж-71, Хүрд компанийн байр	2016-02-15	1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан танилцуулж батлах 2. Компанийн 2015 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах 3. Компанийн 2016 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах 4. Бусад	320935, 325130, 99012597, 99096490 99042205
2016.04.13	Хөвсгөл усан зам	10:00	ХУД, 2-р хороо Номин юнайтед цогцолбор 6 давхрын хурлын танхим	2016-03-20	1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, ТУЗ-ийн дүгнэлт, Гүйцэтгэх удирдлагын тайлан 2. Компанийн ТУЗ-ийн дүгнэлтэд Аудитын хорооноос санхүүгийн тайланд хийсэн дүгнэлт 3. Компанийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор ТУЗ-ийн шийдвэрээс авсан зээлийн талаарх танилцуулга 4. Ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэр танилцуулах	99055111, 99253966
2016.04.14	Монгол шир	15:00	Хан Уул дүүрэг 2-р хороо АШУН-ийн хашаанд Монгол Шир ХК-ийн өөрийн байранд	2016-03-13	1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах 2. Компанийн хувьцаа эзэмшигчдэд 2015 онд ногдол ашиг хувиарлахгүй байхаар шийдсэн ТУЗ-ийн шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах 3. Компанийн 2016 оны төлөвлөгөө	99060160, 91900811, 88009111, 99092210
2016.04.15	Монгол савхи	10:00	Монгол савхи ХК-ийн байранд	2016-03-08	1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан 2. Компанийн ТУЗ-ийн тайлан 3. Аудитын хорооны тайлан 4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох 5. ТУЗ-ийн 2016 оны зардлын төсөв 6. Бусад	99060160, 91900811, 88009111, 99092210
2016.04.15	Хот девелопмент	12:00	Си Би Эм ХХК-ийн хурлын танхим, СБД, 1 хороо, Ландмарк оффис, 4 д	2016-03-20	а. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах б. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах с. 2016 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах d. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох e. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2016 оны зардлын төсвийг батлах f. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах	99422299, 99422805
2016.04.15	Жуулчин говь	13:00	Монгол савхи ХК-ийн байранд	2016-03-08	1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан 2. Компанийн ТУЗ-ийн тайлан 3. Аудитын хорооны тайлан 4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох 5. ТУЗ-ийн 2016 оны зардлын төсөв	93053553, 99250422
2016.04.15	Тулпар	15:00	ТУЛПАР ХК-ны байранд, сургалтын танхимд	2016-03-03	1. 2015 оны компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудиторын дүгнэлт 2. 2015 оны компанийн үйл ажиллагааны тайлан 3. компанийн өөрчлөн байгуулах төсөл 4. ТУЗ-ын гишүүдийн бүрэлдэхүүн сонгох 5. 2016 оны зорилт, бусад асуудал	99422299, 99422805
2016.04.15	Мандалговь импекс	15:00	Хан уул дүүрэг 2-р хороо	2016-03-10	1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан 2. Компанийн ТУЗ-ийн тайлан 3. Аудитын хорооны тайлан 4. ТУЗ-ийн 2016 оны зардлын төсөв	88111316, 99250422, 99060160
2016.04.15	Сүү	15:00	СХД, 29-р хороо, Үйлдвэрчний эвлэлийн гудамж-37, “Сүү” ХК-ийн байр	2016-03-19	1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал, 2. Компанийн хувьцааг хуваах тухай асуудал, 3. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал, 4. Ногдол ашгийн талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх тухай асуудал, 5. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг үргэлжлүүлэх тухай асуудал,	77201100, 99099087
2016.04.15	Э-транс логистик	15:00	УБ, СБД, 8-р хороо 27/1	2016-03-18	1. Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд өөрчлөлт орсноор ХК-ийн дүрэмд аудитын байгууллагыг заавал ажиллуулах тухай заалт оруулах 2. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт 3. Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан 4. Компанийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах 5. Компанийн аудитын хорооны тайлан 6. ТУЗ-ийн гишүүдийг сонгох 7. ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв 8. Ногдол ашиг тараах эсэх тухай	88008702, 95595979
2016.04.15	Оллоо	17:00	СБД, 1-р хороо, Чагдаржавын гудамж, 42-4 тоот	2016-03-04	1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт 2. Компанийн 2016 оны ажлын төлөвлөгөө 3. ТУЗ-ийн гишүүдийг өөрчлөн томилох асуудал	77201100, 99099087
2016.04.18	Баян Алдар	10:00	Улаанбаатар Сүхбаатар дүүрэг 8-р хороо 40-р байр 1 тоот	2016-03-29	1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх 2. ТУЗ-ийн доргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэх, батлах 3. Ноогдол ашиг хувиарлах тухай 4. ТУЗ-ийн гишүүнийг сонгох тухай 5. 2016 онд гаргахаар төлөвлөж буй бүтээгдэхүүний талаар танилцуулах “Будцууг цэцгийн цай” 6. Компанийн 2016 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэх, батлах	70120202, 88026838
2016.04.18	Женко тур бюро	14:00	Төв аймгийн Эрдэнэ сум дахь Чингис хааны морьт хөшөө цогцолборын хурлын танхим	2016-03-21	7. Компанийн ашиг орлого нэмэгдүүлэхтэй холбогдуулан ББСБ-н үйл ажиллагаа явуулах 1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах. 2. Компанийн ноогдол ашиг хувиарлах тухай шийдвэр 3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох 4. Компанийн 2015 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэн батлах. 5. Компанийн үйл ажилгааны төсөв, төлөвлөгөөг хэлэлцэх батлах	7078909
2016.04.20	Монгол шуудан	10:00	МҮЭСТО-ын хурлын бага танхим	2016-03-18	1. “Монгол шуудан” ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай 2. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох 3. Компанийн 2015 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан танилцуулах 4. ТУЗ-ийн 2015 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах	7073263
2016.04.20	Монгол алт	10:00	"Монгол алт"ХК-ийн хурлын танхимд	2016-03-19	1. Компанийн 2015 оны санхүүгийн тайлан 2. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн ажлын тайлан 3. Ногдол ашиг олгох тухай 4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох 5. Бусад асуудлуудыг хэлэлцэнэ.	99264479
2016.04.20	Булган ундрага	11:00	Булган аймаг, Булган сум 4-р баг Зүүн түрүү усны гудамж	2016-03-15	1. Компанийн 2015 оны санхүүгийн тайлан хараат бус аудитын дүгнэлтийг хэлэлцэн батлах 2. Компанийн 2015 оны үйл ажиллагаа болон санхүүгийн цаашдын зорилт хөтөлбөрийг батлах 3. ТУЗ-ийн хараат бус болон ердийн гишүүдийг сонгох 4. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулалын хэмжээг тогтоох 5. 2015 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах эсэх талаар ТУЗ-ийн шийдвэрийг батлах 6. Бусад асуудлууд хэлэлцэх	7073263, 99371230
2016.04.20	Тээвэр дархан	14:00	"Монгол алт"ХК-ийн хурлын танхимд	2016-03-19	1. Компанийн 2015 оны санхүүгийн тайлан 2. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн ажлын тайлан 3. Ногдол ашиг олгох тухай 4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох 5. Бусад асуудлуудыг хэлэлцэнэ.	301577, 99157857,
2016.04.20	Гермес центр	15:00	УБ хот, БГДүүрэг, 4-р хороо, Нарны зам-20, Гермес центр ХК-ны төв оффисын байрны 3 давхар 302 тоот	2016-03-07	1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан 2. Компанийн 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын байгууллагын дүгнэлт 3. Компанийн 2014 оны ногдол ашигийг хуваарилж тараасан тухай мэдээлэл, 2015 оны ногдол ашгийг хуваарилсан болон 2016 оны ногдол ашгийн тухай 4. Компанийн ТУЗ-н болон Гүйцэтгэх захирлын цалин урамшуулал, зардлын төсвийн тухай 5. Компанийн нэгдмэл сонирхолтой этгэд болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны тухай 6. Компанийн 2016 оны үйл ажиллагааны зорилтын тухай 7. Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	323306, 99002083, 88096945
2016.04.22	Зоос гоёл	11:00	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Ж.Самбуугийн гудамж-22 "Зоос Гоёл" ХК-ийн байранд	2016-03-12	1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон хувьцаа нэгтгэх төслийн хэрэгжилтийн үр дүнгийн тухай, 2. Компанийн 2015 оны аудитор баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэл, түүнд хийсэн ТУЗ-ийн /Аудитын хорооны/ дүгнэлтийн тухай, 3. 2015 оны цэвэр ашгаас ногдол ашиг хувиарлах тухай, 4. ТУЗ-ийн 2015-2016 оны зардлын гүйцэтгэл, 2016-2017 оны зардлын төсвийг батлах тухай. 5. Бусад асуудал	99469713, 99092210
2016.04.22	Нако түлш	12:00	Баянгол зочид буудлын хурлын танхим	2016-03-20	1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах 2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах 3. 2016 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах 4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох 5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2016 оны зардлын төсвийг батлах 6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах	99469713, 99092210

Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй • Монголын хөрөнгийн биржийн гишүүн • Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн

Хуралдах он, сар, өдөр	Компанийн нэр	Хурал эхлэх цаг	Хуралдах газар	Бүртгэлийн өдөр	Хэлэлцэх асуудлууд	Холбогдох утас
2016.04.22	Хай би ойл	14:00	Баянгол зочид буудлын хурлын танхим	2016-03-24	1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах 2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах 3. 2016 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах 4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох 5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2016 оны зардлын төсвийг батлах 6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах	99098989, 99092210
2016.04.22	Ундрага-Өмнөговь	14:00	компанийн өөрийн байр	2016-03-21	2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан Ногдол ашгийн талаар ТУЗ-ийн гаргасан шийдвэр ТУЗ гишүүдийг чөлөөлөх шинээр томилох Компанийн хэлбэрийг өөрчлөн ХХК болгох талаар Компанийг өөрчлөн байгуулах төсөл	99072302, 99074431
2016.04.22	Монголын хөгжил үндэсний нэгдэл	14:00	ЧД 2дугаар Самбуугийн гудамж, Орон зай Төв 701 тоотод	2016-03-24	2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэр ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дууссан тул шинээр ТУЗ сонгох Бусад асуудал	91918840, 93221199
2016.04.22	АПУ	15:00	УБ хот, Хан Уул дүүргийн Соёлын ордон	2016-03-14	1. АПУ ХК-ийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах; 2. АПУ ХК-ийн энгийн 1 (нэг) ширхэг хувьцааг тухайн төрлийн 10 (арав) ширхэг хувьцаанд хөрвүүлэх замаар хуваах асуудлыг хэлэлцэж батлах; 3. АПУ ХК-ийн Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж батлах.	341137, 344554
2016.04.22	Азык	15:00	Баян-Өлгий ХК өөрийн байранд	2016-03-16	1. ТУЗ-өөс компанийн 2015 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлт 2. ТУЗ-ийн хараат болон хараат бус гишүүдийг батламжлах тухай	99422071, 70422931
2016.04.22	Хасу-Мандал	15:00	Улаанбаатар хот Хасу холдинг компанийн байранд	2016-03-24	2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэр ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дууссан тул шинээр ТУЗ сонгох Бусад асуудал	
2016.04.22	Ариг гал	17:00	ХУДүүрэг, 15-р хороо, Зайсан 18 гудамж, өөрийн байранд	2016-03-21	1. Хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлнэ. 1.1. “Ариг гал” ХК-ийн 2015 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны талаарх гүйцэтгэх захирлын тайланг хэлэлцэж батлах 1.2 Компанийн 2015 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцэж батлах 1.3. Аудитын байгууллагаас компанийн балансд өгсөн дүгнэлтийг сонсох 1.4. ТУЗ-ийн хараат болон энгийн гишүүдийг сонгох 1.5 Компанийн 2015 оны үр дүнгээс хувыцаа эзэмшигчдэд олгох НА-ыг хуваарилаад 2016 оны НА-тай хамтатган олгох тухай ХЭ-ийн хурал танилцуулга өгөх, 1.6 Компанийн удирдлагын зардлыг хэлэлцэж батлах 1.7 Дүрэмд компанийн хаягтын өөрчлөлтийг оруулж хэлэлцэж батлах. 1.8 “Ариг гал” ХК-ийн охин болон түүний охин компаниудын хувыцааг тухайн компанийн ажилчдад эзэмшүүлэх зөвшөөрөл олгох	343613
2016.04.23	Хөсөг трейд	10:00	компанийн өөрийн байр	2016-03-24	2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэр ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дууссан тул шинээр ТУЗ сонгох Бусад асуудал	99074431, 99119064
2016.04.23	Эвлэл	10:00	компанийн өөрийн байр	2016-03-26	2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэр ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дууссан тул шинээр ТУЗ сонгох Компанийн хэлбэр өөрчлөж ХХК болгох талаар Компанийг өөрчлөн байгуулах төсөл батлах Бусад асуудал	99432500, 99074431
2016.04.23	Шимтлэг	12:00	ЧД, 3-р хороо, Энх тайвны өргөн чөлөө, 54-р байр, Нийс Тауэрын 1306 тоот	2016-03-25	1.Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлах, 2.Компанийн 2015 оны санхүүгийн тайланг хэлэлцэж батлах, 3.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгох, 4.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэлбэр хэмжээг тогтоох	70119568
2016.04.24	Монго	9:00	СХД 29-р хороо „Москва хороолол,Москвгийн гудамж,20 тоот	2016-03-26	Компанийн хувь нийлүүлэгчдийн хурлын 2015 оны ээлжит хурлаар доорхи асуудлуудыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. 1. 2015 оны санхүүгийн жилийн эцсийн тайлан 2. Аудиторын дүгнэлт 3. Байгууллагын 2015 оны үйл ажиллагааны тайлан 4. Байгууллагын үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Хан-Уул дүүргийн 12-р хорооны нутагт байрлалтай 10,7 га газарт төмс, хүнсний ногоо , жимс жимсгэнэ тариалах төслийг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах , шийдвэрлэх 5. Компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар улсын чанартай зохион байгуулагдах ажилд биечлэн оролцох , үйл ажиллагаатай холбоотой асуудлаар санал хэлэлцэж шийдвэр гаргах 6. Эдийн засгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан хойшлогдсон 2013 оны хурлаар баталсан төсөл хөтөлбөрийг дахин хэлэлцэж хэрэгжүүлэх арга замын талаар санал солилцож үйл ажиллагааг эхлүүлэх гарцыг хэлэлцэх 7. Хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх	99038736 , 70173449
2016.04.24	22-р бааз	10:00	компанийн өөрийн байр	2016-03-24	2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэр ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дууссан тул шинээр ТУЗ сонгох Компанийн хэлбэрийг өөрчлөн ХХК болгох талаар Компанийг өөрчлөн байгуулах төсөл батлах Бусад асуудал	70110708, 99116210
2016.04.24	Монгол секюритиес	13:00	Баянзүрх дүүрэг, 8-р хороо, Энх тайвны өргөн чөлөө “22-р бааз” ХК-ийн өөрийн байр	2016-03-24	2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэр ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дууссан тул шинээр ТУЗ сонгох Бусад асуудал	70110708, 99116215
2016.04.24	Түшиг уул	13:00	Улаанбаатар хот СХД 20 хороо Карьер ХХК байранд	2016-03-24	2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэр ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дууссан тул шинээр ТУЗ сонгох Компанийн дүрмийн шинэчлэсэн найруулгыг хэлэлцэж батлах Компанийн нэр өөрчлөх Компанийн цаашдын хэтийн төлвийн талаар хэлэлцэх Нэмэлт хувьцаа гаргах талаар хэлэлцэх Компанийн засаглалын журмууд батлах Бусад асуудал	99103196, 99074431
2016.04.25	Улаанбаатар БУК	11:00	Баянгол дүүргийн 20-р хороо, Дунд голын эрэгт байрлах өөрийн компанийн байранд болно.	2016-03-27	1.Компанийн 2015 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах 2.Ногдол ашгийн талаарх ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах 3.Компанийн хувыцааг жижиглэх тухай 4.Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох 5.ТУЗ-ийн 2016 оны төсөв батлах тухай 6.Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	99097124, 88079542, 88112804
2016.04.25	Ган хэрлэн	15:00	Дорнод аймаг Чойбалсан хот өөрийн байр	2016-03-10	1.Ган Хэрлэн ХК-ний 2015 оны санхүүгийн тайлан 2.Ган Хэрлэн ХК-ний 2015 оны үйл ажиллагааны тайлан 3.Бусад	70584250, 70583050
2016.04.25	Дэвшил мандал	9:30	Чингэлтэй дүүрэг 6-р хороо Бага тойруу 26/1 Вертикал ХХК-ийн байрны 306 тоот	2016-04-01	1. Компанийн 2015 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийн талаар 2. Үйл ажиллагааны тайлангийн талаар 3. Компанийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар 4. Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшиж буй гишүүдийг сонгох талаар 5. Компанид тулгамдаж буй асуудлуудын талаар 6. Бусад асуудлууд	99098866, 99997485
2016.04.25	Сонголон бармат	10:00	СХД, 20-р хороо, компанийн өөрийн байранд	2016-03-22	1.Компанийн 2015 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тухай ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах 2. Компанийн аудитын хорооны дүгнэлтийг батлах 3. 2016 оны бизнес төлөвлөгөө 4. ТУЗ-ийн хараат ба хараат бус гишүүдийг сонгох 5. бусад	96062863, 990005687
2016.04.25	Бидисек	10:00	Сүхбаатар дүүрэг, Залуучуудын өргөн чөлөө 27/1 байр	2016-03-28	а. Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан дүгнэлтийг тайлагнах б. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах с. Компани ногдол ашиг тараах эсэх тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг хэлэлцэж батлах d. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох e. ТУЗ-ийн 2016 оны төсөв батлах f. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай g. Компанийн зарласан болон гаргасан хувыцааны тоог тогтоох тухай	11-313108, 94092846
